

switchasia
GRANTS PROGRAMME



SUSTAINABLE
PLASTIC
RECYCLING
IN MONGOLIA




ХУВАНЦАР ХАЯГДЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ӨНӨӨГИЙН ЭРХЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Н. ЭРДЭНЭСАЙХАН, (PhD) Төслийн ажилтан
Б. ТҮМЭНЖАРГАЛ, Төслийн туслах ажилтан
БАЙГАЛЬ ОРЧИН, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨВ ТББ

Улаанбаатар хот
2022 оны 1 сар



Энэхүү тайланг Каритас Чех Репаблик болон хамтрагч байгууллагуудын хэрэгжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд гаргав. Энэхүү тайланд орсон агуулга нь зөвхөн төслийн хамтран хэрэгжүүлэгч Байгаль орчин, аюулгүй байдлын төв ТББ-ын үзэл бодол бөгөөд Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
ХУВАНЦАР ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА	5
ОРШИЛ	5
БҮЛЭГ I. Эрхзүйн баримт бичгүүдийн шинжилгээ.....	5
Эрхзүйн баримт бичгүүдийн холбогдох заалтуудын ач холбогдол.....	7
Эрхзүйн орчны хэрэгжүүлэх боломж ба хэрэгжилтийн байдал.....	8
Хуулийн хэрэгжилт дэх төрийн байгууллагуудын үүрэг, оролцоо.....	11
Хог хаягдлын менежмент дэх бусад талуудын оролцоо	12
БҮЛЭГ II. Европын Холбооны хог хаягдлын менежмент, хуванцар хаягдалтай холбоотой эрхзүйн орчны тойм	13
БҮЛЭГ III. Хуванцар хаягдлын зохистой удирдлагад эрхзүйн зохицуулалтын талаас тулгарч буй саад бэрхшээлийн тойм ба шийдэл.....	17
Одоогийн эрхзүйн орчинд байгаа хуванцар хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болох заалт .	18
Одоогийн эрхзүйн орчны хэрэгжилтийг хангуулах.....	19
Эрхзүйн орчныг сайжруулах шаардлага.....	20
БҮЛЭГ IV. Дүгнэлт ба Зөвлөмж.....	21



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН- Аж ахуйн нэгж

АИТХ- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал

БОАЖЯ- Байгаль орчин, аялал жуулчлалын яам

ЕХ- Европын Холбоо

ЕХПБХЗ- Европын Холбооны Парламент ба Холбооны Зөвлөл

ЕК – Европын Комисс

ИТХ- Иргэдийн төлөөлөгчдийн хурал

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

НИТХ- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал

ОНӨҮГ- орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

СӨХ- Сууц өмчлөгчдийн холбоо

ТҮК – Тохижилт үйлчилгээний компани

УБ - Улаанбаатар хот

ХХДБ- Хуванцар хаягдлыг дахин боловсруулах



ХУВАНЦАР ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

ОРШИЛ

Европын холбооны Switch-Asia II хөтөлбөрийн санхүүжилтээр Монгол улсад хэрэгжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийн хүрээнд хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах, дахивар нөөцийн ангилалт, цуглуулалт, тээвэрлэлтийг үр дүнтэй явуулах эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх ажлын хэсэг байгуулах, хэлэлцүүлэг зохион байгуулахад ашиглах зорилгоор төслийн зорилтот байршил болох Улаанбаатар хот, Булган аймаг, Хишиг-Өндөр суманд хамаарах хог хаягдлын эрхзүйн баримт бичгүүдийн судалгааг хийлээ.

Энэхүү судалгааны хүрээнд Монгол улсын Хог хаягдлын тухай хууль /2017/, хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр /2014/, хуванцар хаягдалтай холбоотой засгийн газрын тогтоол, яамдын сайдын тушаал, Улаанбаатар хот, Булган аймаг, Хишиг-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, засаг даргын захирамж заалтууд хаягдлын удирдлага, зохицуулалтын зэрэг эрхзүйн баримт бичгүүдийн хуванцар хаягдлыг бууруулах дахин боловсруулахад үзүүлэх ач холбогдол, хэрэгжилт, түүнд үзүүлэх төрийн байгууллага болон бусад оролцогч талуудын хандлага ба оролцоо зэрэг хүчин зүйлүүдээр шинжилгээ хийн Европын Холбооны хог хаягдал, хуванцар хаягдлын чиглэлээрх эрхзүйн үндсэн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээтэй харьцуулан судалсны үндсэн дээр хуванцар хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх таатай эрх зүйн орчин бүрдүүлэхэд авч хэрэгжүүлж болох үйл ажиллагааны зөвлөмжийг боловсруулав.



БҮЛЭГ I.

Эрхзүйн баримт бичгүүдийн шинжилгээ

Энэхүү судалгаанд хуванцар хог хаягдлын зохицуулалттай холбогдох дараах эрхзүйн баримт бичгүүдэд шинжилгээг хийлээ.

Үүнд:

1. Хог хаягдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2017
2. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, 2014
3. Зөрчлийн тухай хууль (6.1 дүгээр зүйл: хог хаягдлын тухай хууль зөрчих), 2017
4. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага, БОАЖ-ын сайдын 2018.11.17 ны өдрийн А/443 тоот тушаалын хавсралт
5. Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралт
6. Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай, Монгол улсын засгийн газрын 2018 оны 6 сарын 20-ны өдрийн 189 тоот тогтоол
7. Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалтад нэмэлт оруулах тухай, Монгол улсын засгийн газрын тогтоол, 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн №199 тогтоол
8. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам, НИТХ -ын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 тоот тогтоолын хавсралт
9. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам. Нийслэлийн Засаг даргын захирамж 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/492 захирамжийн хавсралт №1
10. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулах гэрээ. Нийслэлийн Засаг даргын захирамж 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/492 захирамжийн хавсралт №2
11. MNS 5105 : 2001-Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
12. Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөр (Булган хотын хатуу хог хаягдлын менежментийн төлөвлөгөө батлах тухай” Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын 19-ны 140 дугаар тогтоол). Шинэчлэн боловсруулах ажил хүлээгдэж байгаа:



13. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам. Булган аймгийн ИТХ-ын 2021 оны IV хуралдааны IV/8 тогтоол
14. Цэвэр орчин-Цэмцгэр Булган аян зохион байгуулах тухай, Булган аймгийн Засаг даргын 2016 оны А/180, 2017 оны А/182, 2018 оны А/194, 2019 оны А/209, 2020 оны А/166 тоот захирамж
15. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам батлах тухай, Булган аймгийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/220 тоот захирамж
16. Сумын төвийн хог хаягдлыг тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэх зарцуулах журам, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ИТХ-ын тогтоол 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр. Дугаар 12/05
17. Сумын төвийн хог хаягдлыг тээвэрлэх үнэлгээний журамд өөрчлөлт оруулах тухай, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ИТХ-ын тогтоол 2017 оны 3 дугаар сарын 21. Дугаар 3/10
18. Цэвэр орчин- Цэмцгэр сум аян зохион байгуулах тухай, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Засаг даргын захирамж. 2021 оны 4 дүгээр сарын 20. Дугаар: А/52
19. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай, Нийслэлийн захирагч бөгөөд Улаанбаатар хотын даргын захирамж. 2021 оны 12 дугаар сарын 20. Дугаар: А/987

Эдгээр хүчин төгөлдөр үйлчилж буй эрхзүйн баримт бичгүүдэд дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан шинжилгээг хийлээ. Үүнд:

- Хууль эрхзүйн холбогдох заалтуудын хуванцар хаягдлыг багасгаж, бага зардлаар үр ашигтай цуглуулах, дахин боловсруулах үйл хэрэгт оруулах хувь нэмэр (ач холбогдол)
- Хууль эрхзүйн заалтуудын хэрэгжих боломж болон өнөөгийн хэрэгжилт
- Төрийн байгууллагуудын эрхзүйн хэрэгжилт дэх үүрэг оролцоо,
- Хуванцар хаягдлын менежмент дэх оролцогч талуудын хандлага ба оролцоо зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзлээ.

Эрхзүйн баримт бичгүүдийн холбогдох заалтуудын ач холбогдол

Дээрх эрхзүйн баримт бичгийн дотор хуванцар хаягдлыг үр ашигтай цуглуулж, боловсруулан, эдийн засгийн эргэлтэнд оруулах, тогтвортой, эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй ажлын байр бий болгоход чухал үүрэг гүйцэтгэх заалтуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэх нь хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээлийг тогтоох, заалтуудыг хэрэгжүүлэхэд төрийн хяналтыг сайжруулж, олон нийтийн оролцоог бий болгох замаар саад бэрхшээлийг арилгах арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Тэдгээр заалтуудыг дараах байдлаар эрэмбэлж байна.



1. Хог хаягдлын хуулийн заалтууд

- Хог хаягдлыг, түүний дотор хуванцар хаягдлыг үүсгэгч нь хаягдлаа өөрөө хариуцах, тухайлбал аюулгүй хадгалах, зайлуулах, эсвэл дахин боловсруулахаар эрхээ шилжүүлэх хүртэл хаягдлаа хариуцах заалтыг 2017 оны хуулийн шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйлд (5.1-5.4) тусгасан нь зах зээлийн нийгэм дэх хог хаягдлын зохистой удирдлагын гол чухал ач холбогдолтой заалт болсон. Хуванцар хаягдлыг үүсгэгч өмчлөх эрхээ хуванцар хаягдлыг дахин боловсруулахаар цуглуулагчид шилжүүлснээр өмчлөх эрх дуусгавар болно. Энэ заалтыг хог хаягдал үүсгэгч иргэн, ААН байгууллага бүрт сайн ойлгуулж сурталчлах ажил нэн тэргүүнд шаардлагатай.
- Хуулийн 10 дугаар зүйлд Хог хаягдлаа ангилан ялгахыг иргэд ААН, байгууллагуудад үүрэг болгосон нь 2017 оны хуулийн чухал заалтуудын нэг юм. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд ангилан ялгасан дахиварыг цуглуулах, хүлээн авах түр цэгүүд, дахин боловсруулагч нарын үүсгэсэн сүлжээний хаяг байршлын мэдээлэл, хэрхэн нийлүүлэх талаар зааварчилгааг тодорхой болгож олон нийтэд түгээх зайлшгүй шаардлагатай байна.

2. БОАЖ, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 тоот тушаалын хавсралтаар баталсан “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”

- Хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах: Хуванцар сав суулга, түүхий эд болон нийлэг уут түүний түүхий эд үйлдвэрлэх, импортлох үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна гэж оруулсан. Энэ заалт нь төдийлөн хэрэгжиж эхлээгүй, эхлэл, санаачилга төдий байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй хийснээр хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах ажил эрчимтэй явагдах болно.

3. НИТХ -ын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 тоот тогтоолын хавсралт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”

- Журмын 8-р зүйлд (8.10.) төрийн болон төрийн өмчийн оролцоотой, хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжүүд бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа хог хаягдлыг дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд сонгоно. Энэ заалт одоогийн байдлаар хэрэгжээгүй бөгөөд хуванцар хаягдлыг дахин боловсруулагчдын хувьд бүтээгдэхүүнээ борлуулах том боломж олгож буй хамгийн хүлээлттэй заалт юм. Энэ заалтын хэрэгжилтийг хангуулахад Нийслэлийн засаг даргын тамгын



газрын шууд дэмжлэг, оролцоо голлох үүрэгтэй байна. Мөн нийлүүлэх бүтээгдэхүүний хувьд хаана хэрэглэхээс хамаарч байгаль, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эсэх, энэ талаар баримтлах тодорхой стандарт журам гараагүй байгаа нь хэрэгжилтийг хангахад учирч буй нэг бэрхшээл гэж үзэж байна.

Эрхзүйн орчны хэрэгжүүлэх боломж ба хэрэгжилтийн байдал

Хог хаягдлын тухай хуульд:

Хог хаягдлын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 14 -р зүйлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг /ажуйн хуванцар хог хаягдал үүнд багтана/ цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэхэд сум, дүүргийн засаг захиргаанаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулахыг шаарддаг бөгөөд

- Хуванцар хаягдлыг цуглуулахын тулд бүртгүүлж, дугаар авна.
- Тухайн засаг захиргааны нэгжийн даргатай гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагааг эрхлэхийг шаардсан байна.

Нэг талаас хуванцар хаягдлыг цуглуулагч нарын нилээд хэсгийг сайн дурын цуглуулагч нар эзлэх бөгөөд эдгээр шаардлага нь иргэдийн хуванцар хаягдлыг цуглуулах үйл ажиллагаанд саад болохоор байна. Нөгөө талаас дахин боловсруулах хаягдлыг эдийн засгийн эргэлтэд энэхүү хууль хэрэгжиж эхлэхээс өмнө оруулж, хаягдлын хэмжээг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулж ирсэн албан бус түүгчдэд биелүүлэхэд төвөгтэй, өндөр шаардлага тавих нь хуванцар хаягдлыг цуглуулах тогтолцооноос хасажбуйтай адил ба энэ зохицуулалт ыг өөрчлөх, сайжруулах шаардлагатай.

Хуулийн Зургадугаар бүлгийн 40-р зүйл. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай хэсэгт хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглахыг дэмжих, энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахтай холбоотой чухал заалтууд орсон бөгөөд эдгээр заалтуудын хэрэгжилт хуванцар хаягдлын чиглэлээр ажилладаг иргэд, ААН-үүдэд өндөр ач холбогдолтой. Гэсэн хэдий ч хэрхэн яаж хэрэгжүүлэх механизмыг тодорхой зааж өгөөгүйгээс эдгээр заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

- Тухайлбал, 40.3-т иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүн худалдан авах замаар ногоон худалдан авалтыг дэмжинэ хэмээн заасан энэхүү заалт маш хэрэгтэй заалт боловч бодит байдалд хэрэгжээгүй байгаа. Хэдийгээр иргэд, ААН-ийн хувьд ямар барааг хаанаас авах нь тэдний хэрэг боловч төрийн хөрөнгөөр бараа худалдан авах журамд бараа бүтээгдэхүүний тодорхой хувийг дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүнээс авахаар тусгах, тендерийн шалгуур үзүүлэлтэд оруулах байдлаар зохицуулах шаардлагатай. Дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг төрийн байгууллагууд худалдан авдаг явдлыг дэмжихийн тулд эдгээр бүтээгдэхүүний агуулгад байгаа химийн бодис нь ашиглалтын явцад болон хаягдал болсны дараа хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх баталгааг бий болгохын тулд үйлдвэрлэлд тавих



стандарт шаардлагыг боловсруулж, бүтээгдэхүүн нь нийцэлтэй эсэхийг хянаж, тодорхой тэмдэг, шошго олгох шаардлагатай. Хоёрдогч түүхий эд цуглуулагчид, хуванцар хаягдал дахин боловсруулагчид, төрийн худалдан авах ажиллагаа хариуцсан төрийн байгууллагын оролцоотойгоор энэ асуудлыг шийдэж, эрхзүйд тусгах, холбогдох стандартыг боловсруулах шаардлагатай.

- 40.4-т хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно гэж заажээ. Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 290 тоот тогтоолын хавсралтаар “Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам” баталсан. Одоогийн байдлаар 20 гаруй ААН-үүдэд ногоон гэрчилгээ, эко-тэмдэг олгоод байгаа гэсэн БОАЖЯ-ны мэдээлэл байна. Түүнчлэн 2021 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар (ИТХ)-р Улаанбаатар хотын “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлсэн болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох” журмыг хэлэлцэж эхэлсэн бөгөөд хараахан батлагдаагүй байна. Уг журмыг батлах нь энэхүү хуулийн заалтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг болно.
- 40.5. Хуулийн 8.1.14-т заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А429/257 тушаалын хавсралтаар батлагдсан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй гэж заажээ. Уг жагсаалтад хуванцар сав суулга, түүхий эд, нийлэг уут, түүний түүхий эд орсон бөгөөд үйлдвэрлэгч, импортлогч нь эргүүлэн цуглуулж, боловсруулах үүргийг хүлээж байгаа. Энэхүү заалтын хэрэгжилтийг хангахад уг заалтыг хэрэглэгчдэд таниулах, үйлдвэрлэгч, импортлогчдод хэрэглэгчдийн зүгээс шаардлага тавих, төрийн байгууллагын зүгээс хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай ба бусад шийдлийг бий болгох тал дээр төрийн болон иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрлэгч, импортологчдын төлөөллийн дунд хэлэлцүүлэг явуулах шаардлагатай.

ИТХ -ын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 тоот тогтоолын хавсралт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-д:

Хог хаягдлын тухай хуулийн заалтуудыг УБ хотын хэмжээнд нарийвчлан хэрэгжүүлэх шаардлагуудыг багтаасан бөгөөд журмыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Харин зарим заалтуудыг илүү тодорхой болгох шаардлагатай.



Тухайлбал:

- “6.5. Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэг нь үйл ажиллагаандаа холбогдох стандартыг мөрдөж ажиллана” гэсэн заалтад “холбогдох стандарт” хэмээн тодотгосон стандартыг илүү тодорхой болгох шаардлагатай. Одоогийн байдлаар дахивар худалдан авдаг цэгүүд, түр хадгалах цэгүүдэд ямар нэгэн мөрддөг стандарт байхгүй бөгөөд цаашид эдгээр цэгүүд тодорхой байршилд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэхийн тулд ямар дахиврын төрөлд ямар стандартыг дагаж мөрдөх ёстой тухай эрхзүйн орчныг бий болгох шаардлагатай. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А987 дугаар захирамжаар хүнд суртлыг багасгах, иргэд ААН-үүдэд Нийслэлийн төр захиргааны байгууллагаас үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах зорилгоор 74 төрлийн үйлчилгээнд тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй, зөвхөн татварын албанд бүртгүүлж, холбогдох стандарт, журмын шаардлагуудыг баримтлан ажилладаг болох зохицуулалтыг хийсэн. Энэ үйлчилгээнд дахивар цуглуулах цэгийн үйлчилгээг оруулжээ.
- “6.6. Дахин боловсруулах боломжтой энгийн хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэг нь орчны аюулгүй байдлыг хангасан, журмын 6.3 дахь заалтад заасны дагуу хог хаягдлыг төрөлжүүлэн, агуулахад эмх цэгцтэй хадгалж, хог хаягдлыг овор хэмжээг багасгах нягтруулах төхөөрөмжтэй байна” гэсэн заалт дахь “орчны аюулгүй байдлыг хангасан” гэдэг ухагдахууныг илүү дэлгэрэнгүй, ойлгомжтой болгох шаардлагатай. Одоогийн байдлаар дахивар хадгалах цэгийн тусгайлсан стандарт байхгүй боловч БНБД 31-19-10-Агуулахын барилгын норм ба дүрэм, MNS 5105 : 2001-Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага зэргийг дахивар нөөцийн цэг дагаж мөрдөх боломжтой байна. Гэвч MNS 5105 : 2001-Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага-д эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 50-1000 м хүртэл 5 хуваасны дотор “хатуу хог хаягдлыг цуглуулах тохижуулсан газар талбай”, “түүхий хаягдлын үндсэн агуулах”, “хаягдлыг боловсруулалт хийлгүйгээр түр хадгалах агуулах” зэрэг дахивар нөөцийн цэгийг илтгэж болох байгууламжууд өөр өөр бүсэд хамаарагдаж байгаа ба тэдгээрийн ялгааг тодорхой заахгүй бол ААН-үүд болон төрийн хуулийн хэрэгжилтийг хангуулах албан тушаалтан өөр өөрийн өнцгөөс тайлбарлаж, үл ойлголцох байдал үүсэх магадлал өндөр байна. Уг шаардлагыг илүү тодорхой болгож өгөх нь тухайн чиглэлээр бизнес эрхлэгч, иргэдэд байршлаа зөв сонгох, цуглуулах дахиврын төрлөө сонгох, ажлын байраа тохижуулахад шаардагдах хөрөнгө оруулалтаа тооцох зэрэг ажилд чухал мэдээлэл болох юм.

Булган аймгийн ИТХ-ын 2021 оны IV/8 тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-д:



Уг журамд орон нутгийн онцлог, давуу талыг тодорхой тусгаагүй, ерөнхий заалтууд орсон нь хэрэгжилтэд саад учруулах магадлалтай. Үүнээс гадна БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 тоот тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах Ерөнхий шаардлага”-ын 2.2.2-д заасан дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэж 4 заавал ангилах шаардлагыг энэ журамд тусгаагүй, одоогийн байдлаар аймгийн төв Булганд сумдын айл өрхүүдэд бэлтгэн өгсөн дахин ашиглах хаягдал ба бусад хаягдал хийх 2 төрлийн саванд тохируулан зөвхөн 2 ангилахаар журамдаа оруулсан нь эрхзүйн баримт бичиг хоорондын уялдаа холбоог алдагдуулж байна.

Иймээс Булган аймгийн ИТХ-ын 2021 оны IV/8 тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын хог хаягдлыг ангилан ялгах 3.1.2 заалтад орон сууцны иргэдэд дахин ашиглах, хүнсний хаягдал болон бусад гэж 3 ангилах, гэр хорооллын айл өрхөд хог хаягдлаа дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад хэмээн 4 ангилан ялгах шаардлагыг оруулж, энэхүү журмыг шинэчлэх шаардлагатай байна.

Хуулийн хэрэгжилт дэх төрийн байгууллагуудын үүрэг, оролцоо

Хог хаягдлын тухай хууль, түүний дагалдах журмуудын хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглахтай холбогдох ач холбогдол бүхий дээр дурдсан заалтуудын хэрэгжилт одоогийн байдлаар хангалтгүй байгаа нь төслийн оролцогч талуудаас авсан судалгаанаас харагдсан ба тэдгээрийг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын оролцоо чухал үүрэгтэй. Жишээлбэл, **Хог хаягдлын тухай хуулийн** “Хог хаягдлын талаар иргэн, ААН-ын эрх үүрэг” хэмээх 10 дугаар зүйлд УБ хотын ИТХ-аас баталсан хог хаягдлыг журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагыг судалгаанд¹ оролцогсдын 80 хувь нь биелүүлдэггүй буюу ангилж ялгадаггүй, ангилсан ч нэг машинд ачаад явчихдаг, эсвэл, ангилсан ч тушаах газар байхгүй гэх байдлаар хариулсан байна. Үүнээс харахад хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна төрийн байгууллагын зүгээс хууль, журмыг сурталчлан таниулах, хэрэгжилтэд хяналт тавих, дахивар хаягдлыг тогтвортой цуглуулах, тээвэрлэх зохион байгуулалт, дэд бүтцийг бий болгох зайлшгүй шаардлагатай. Нэгэнт батлагдсан Хог хаягдлын тухай хууль, дагалдан гарсан журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулах асуудал дахин хууль эрхзүйд нэмэлт өөрчлөлт оруулахаас илүү чухал ач холбогдолтой ба түүнд УБ хотын Захирагчийн ажлын алба, аймаг/нийслэлийн Засаг даргын тамгын газар, сум/дүүргийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд, баг/хороодын Засаг дарга нар, мэргэжлийн хяналтын газар, хог хаягдлын олон нийтийн байцаагч, баг/хэсгийн ахлагч зэргийн харилцан уялдаа бүхий идэвхтэй оролцоо шаардлагатай байна.

Хог хаягдлын менежмент дэх бусад талуудын оролцоо

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд хууль эрхзүйн баримт бичигт туссан зарим талуудын үүрэг оролцоог өөрсдөд нь таниулах, илүү тодорхой

болгох шаардлагууд байна. Дахин боловсруулах, сэргээн ашиглах хаягдал үүний дотор хуванцар хаягдалтай холбоотой зарим талуудын эрх, үүрэг оролцоо өнөөгийн хог хаягдлын хууль эрхзүйн орчинд байхгүй байна.

- a) Тухайлбал, орон сууцны хорооллын хог хаягдлын зохицуулалтад гол нөлөөтэй орон сууцанд оршин суугчдын төлөөлөл болох Сууц өмчлөгчдийн холбооны эрх үүрэг хог хаягдлын тухай хуульд орхигдсон боловч Нийслэлийн энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын гуравдугаар бүлэгт үүргийг нь тодорхой оруулсныг таниулах, чиг үүргээ биелүүлэхэд нь хяналт тавих чухал. Уг журмын 2.4-д заасан дүүргийн засаг даргын чиг үүргийн хүрээнд улиралд 2-оос доошгүй удаа дүүргийн нутаг дэвсгэр дэх иргэд, аж ахуйн нэгж, сууц өмчлөгчдийн холбоодод хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулахаар заасан байгаа ба уг сургалтаар чиг үүргийг нь таниулах шаардлагатай.
- b) Мөн түүнчлэн сайн дураар дахивар цуглуулж, дахивар нөөцийн цэгт тушаадаг иргэд хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хогийн цэгт булагдаж буй хогны хэмжээг бууруулахад өндөр хувь нэмэр оруулахын сацуу өөрсдийн амьжиргааг залгуулдаг боловч одоогийн эрхзүйн орчинд тэдгээр иргэдийг үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэн үргэлжлүүлэхэд тавих шаардлагууд биелүүлэхэд төвөгтэй, шаардлагуудыг хангаж зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулснаар хүртэх үр шим, урамшуулал тодорхойгүй байгаагаас албан бусаар үйл ажиллагаа явуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд оролцохгүй орхигдох байдал үүсч байна. Хуулийн 9.5.7-д хог хаягдлын талаар баг, хорооны Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхийн хүрээнд хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах тухай заалт байгаа ба энэхүү заалтыг хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгаж дахивар цуглуулдаг иргэдийг зохион байгуулалтад оруулж, тэдний оролцоог дэмжин албажуулах нь зүйтэй.
- c) Нийслэлийн энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын хоёрдугаар бүлэгт дүүргийн нийт айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын ачилт цуглуулалт, тээвэрлэлтийн үйлчилгээг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Хог хаягдлын тухай хуулийн есдүгээр зүйлийн 9.4.2-т заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр заасан байдаг. Харин уг журмын 7-р бүлэг 7.4-т “Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээ”-нд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хөндлөнгийн хяналтын төрийн бус байгууллага хог хаягдлын үйлчилгээний байгууллагад хяналт тавьж, сар бүрийн ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгөх тухай заасан байна. Ийм “хөндлөнгийн хяналтын төрийн бус байгууллага”-ын үүрэг үйлчилгээг сайжруулахад чухал үүрэгтэй ба журмын энэ заалт яаж хэрэгжиж байгаа болон ямар байгууллага хяналт тавьж болох талаар тодорхой мэдээллийг олон нийт авч байх хэрэгтэй.



Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах таатай эрхзүйн орчныг бий болгох, дээр дурдсан хууль, журмын заалтын хэрэгжилтийг сайжруулахад хуванцар хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, боловсруулах үйл ажиллагаанд оролцогч талуудын төлөөллийг бүрэн оролцуулсан ажлын хэсэг зохион байгуулж хэлэлцүүлэн, шийдэл гаргах шаардлагатай.



БҮЛЭГ II.

Европын Холбооны хог хаягдлын менежмент, хуванцар хаягдалтай холбоотой эрхзүйн орчны тойм

Хог хаягдлын удирдлага болон хуванцар хаягдлыг цуглуулах, тээвэрлэх дахин боловсруулж ашиглах удирдлагыг оновчтой болгон сайжруулах чиглэлээр олон улсад баримталж буй тогтвортой, ногоон хөгжлийн зарчмуудыг Монгол улсын хог хаягдлын тухай өнөөгийн хууль, холбогдох бусад эрхзүйн баримт бичигт тусгах боломжийг судлах үүднээс Европын холбооны (ЕХ) хог хаягдал, хуванцар хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой эрхзүйн зарим үндсэн бичигт баримтуудыг судалж, үр дүнг энэхүү судалгаанд авч ашиглалаа. Эдгээр эрхзүйн баримт бичигт хог хаягдлын менежмент болон хуванцар хаягдлыг дахин боловсруулж, ашиглахад баримталж буй ногоон хөгжил, тойрог эдийн засгийн зарчмууд, тэдгээрийн уялдаа холбоо, цогц хандлагыг хэрхэн тусгасныг судаллаа. Ашигласан баримт бичгүүдийн жагсаалтыг доор үзүүлэв.

Үүнд:

1. Европын Холбооны Парламентын ба Холбооны Зөвлөлийн (ЕХПБХЗ) Хог хаягдлын 2008/98/ЕС директив. 2008 оны 11 дүгээр сарын 19-нд баталсан. Директив нь ЕХ-ны гишүүн орнуудын хог хаягдлын чиглэлээр хүрэх тодорхой зорилтуудыг тусгасан эрхзүйн бичиг баримт бөгөөд энэхүү директивийн үндсэн дээр ЕХ-ны гишүүн улсууд өөрийн холбогдох хууль эрх зүйн актад тэдгээр зорилтуудад хүрэхэд чиглэсэн тодорхой зохицуулалтыг тусгаж өгдөг.
2. ЕХПБХЗ -ийн Сав баглаа боодол болон түүний хаягдлын тухай 94/62/ЕС директив. 1994
3. ЕХПБХЗ -ийн Хөнгөн жингийн нийлэг уут ашиглалтыг бууруулах талаар 2015/720 директив (94/62/ЕС директивийн өөрчлөлт)
4. Европын Комиссын (ЕК) Тойрог эдийн засгийн үйл ажиллагааны шинэ төлөвлөгөө, 2020.3.11
5. ЕК-ийн Тойрог эдийн засаг дахь Хуванцрын талаарх Европын стратеги, 2018.1.16
6. ЕХПБХЗ -ийн Зарим хуванцар бүтээгдэхүүний байгаль орчинд учруулж буй нөлөөллийг бууруулах тухай 2019/904 директив. 2019.6.5

Эдгээр эрхзүйн баримт бичгийн агуулгад хийсэн дүн шинжилгээний үр дүнгүүдийг сийрүүлбэл:

- Хог хаягдлын 2008/98/ЕС директивт Монгол улсад ашиглаж байгаа эрхзүйн баримт бичиг, ялангуяа хог хаягдлын хуультай харьцуулбал дараах онцлог асуудлыг тусгажээ. Энэ директивийн үйлчлэх хүрээнд ямар хог хаягдлыг багтаасан, ямар зүйлсийг багтаагүй гэдгийг маш тодорхой оруулсан байна. Тухайлбал, барилгын зориулалтаар ухсан газраас гарсан хөрс, өнгөн хөрс, шороо химийн бодисоор бохирдоогүй тохиолдолд хог биш, малын өтөг баас, сүрэл, түүсэн, хадсан ургамлыг хог гэж тооцохгүй, цаас модны хаягдлыг эрчим хүч гаргахад ашигтай учир хог хаягдалд оруулахгүй, ашиглаагүй ч гэсэн гэж тусгасан нь хог тээвэрлэх зардал, ландфиллд орох хаягдлын хэмжээг бууруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжтой байгалийн нөөц баялгийг хог гэж булшлахаас сэргийлэхэд их хувь нэмэртэй заалт байна.
- Директивийн Нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд хог хаягдлын менежментэд баримтлах тэргүүлэх ач холбогдлыг шатлан гаргажээ. Тухайлбал:
 - а) Үүсэхээс сэргийлэх
 - б) Дахин ашиглахад бэлтгэх
 - в) Дахин боловсруулах
 - д) Бусад замаар сэргээн ашиглах жишээлбэл эрчим хүч үйлдвэрлэх
 - е) Булшлах, устгах

Эдгээр асуудлуудыг манай хог хаягдлын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйл “Хуулийн зорилт”-д ерөнхий байдлаар оруулсан, мөн нэр томъёоны тодорхойлолтод ч тайлбарласан байдаг. Гэхдээ хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх асуудал тодорхой тусгагдаагүй. Энэхүү директивт тэргүүлэх ач холбогдлоор жагсаасан асуудлууд директивийн бүтцэд энэ дарааллаараа бүлэг, заалт болон тусгагджээ. Тухайлбал, директивийн хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх заалт Бүлэг II Ерөнхий шаардлага-д заалт 9 болгон оруулсан. Хог хаягдал үүсэхээс сэргийлэх нэн тэргүүний шаардлагад хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх судалгаа, арга хэмжээний тодорхой хөтөлбөр боловсруулж, гишүүн орнуудын холбогдох эрхзүйн баримт бичигт оруулахыг үүрэг болгожээ. Үүний дотор, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийн дизайныг хог хаягдал бага үүсгэх, хүн, байгальд хортой бодисоос зайлсхийсэн байхаар боловсруулах хамгийн боломжит арга технологи ашиглан хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх зорилтуудыг тодорхой хугацааны дотор бий болгохыг мөн гишүүн орнууддаа үүрэг болгожээ.

- Тойрог эдийн засгийн үйл ажиллагааны шинэ төлөвлөгөө болон Хуванцрын стратегийн хог хаягдал үүсэхээс сэргийлэх бодлого, арга хэмжээнүүдэд бүтээгдэхүүний эко-дизайнаас гадна эко-шошго буюу ногоон тэмдэг нэвтрүүлэх, төрийн ногоон худалдан авалтын бодлого хэрэгжүүлэх, бүтээгдэхүүний байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх



нөлөөллийн журам гаргах зэрэг асуудлуудыг оруулжээ.

- Дээрх тэргүүлэх ач холбогдол бүхий заалтуудыг директивийн “Бүлэг II Ерөнхий шаардлага”-д нэг бүрчлэн тусгаснаас гадна хамгийн эхний заалт нь үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага буюу үйлдвэрлэгч, импортлогч зарсан барааныхаа сав баглаа боодлын хаягдлыг эргүүлэн татан авах тухай байна. Үүний дараа хог хаягдал үүсэхээс сэргийлэх асуудал оржээ. Хэрэв манай эрхзүйн баримт бичгүүдэд энэ тэргүүлэх ач холбогдлын зарчмыг тусган хэрэгжилтийг хангаж чадвал хог хаягдлын хэмжээ ихээхэн багасч, үүний хирээр нэгэнт үүссэн хог хаягдлыг менежмент хийхэд тулгарч буй асуудал алга багасна гэж үзэж байна.
- Төсөв хөрөнгө багатай, хөгжиж байгаа манайх шиг улсын хог хаягдлыг зохицуулахтай ижил төстэй хууль журмуудад бүх хийх ажлаа жагсаан бичиж, бүгдийг нь нэгэн зэрэг хэрэгжүүлэх гэдэг хандлага түгээмэл байдаг бөгөөд үүний сөрөг үр дагавар нь эдгээр жагсаасан бүх ажлаа хэрэгжүүлэх төсөв хөрөнгө бага, боловсон хүчин дутагдалтай байдгаас хэрэгжилт нь бага, үр өгөөж муу байдаг. Иймээс тэргүүлэх ач холбогдол тогтоож, хамгийн гол асуудалдаа нэн тэргүүн анхаарлаа хандуулж ажиллах зарчмыг Монгол улсад байнга хэрэглээ болгох шаардлагатай.
- ЕХ-ны гишүүн орнуудын хүрээнд үүсч буй хуванцар хаягдлын 40%-г барааны сав баглаа боодол эзэлдэг² байна. Иймээс хуванцар хаягдлын гол эх үүсвэрт чиглэсэн бие даасан эрхзүйн орчин бий болгож, гишүүн орнуудынхаа хуванцар хаягдлын менежментийг зөв гольдролд оруулах ажлыг ЕХ хийсэн байна. Сав баглаа боодол болон түүний хаягдлын тухай 94/62/ЕС директивт бүх төрлийн сав баглаа боодлыг хаягдал үүсэхээс сэргийлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, эргүүлэн татах, цуглуулах бодлого, арга хэмжээний зорилт, зорилтын хамгийн бага ба хамгийн их босго хэмжээ, цаг хугацаа зэргийг зааж өгсөн байна. Мөн түүнчлэн ашигласан сав баглаа боодлыг хэрэлэгч тушаах, буцааж хүргүүлэх, сэргээн ашиглах тогтолцоо, цэгүүдийг бий болгож, хэрэглэгчдийн үүрэг, хариуцлага, сав баглаа боодлын ангилал, шошгоны тайлбар зэргийн мэдээллийг бэлтгэж түгээх арга хэмжээг зохион байгуулж, сав баглаа боодлыг бүлэглэн ангилж шошгожуулах, бүртгэх ажлуудыг хийж гүйцэтгэхийг даалгажээ. Үйлдвэрлэгч болон импортлогч нь хариуцах сав баглаа боодлын хаягдлын жагсаалтыг Байгаль орчин, аялал жуулчлал болон Сангийн сайд нарын 2018 оны А429/257 дугаар тушаалаар баталсан бөгөөд энэ жагсаалтанд хуванцар сав, суулга, нийлэг уут, эдгээрийн түүхий эд орсон. Энэ жагсаалтанд орсон хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогчид хэрхэн үүргээ биелүүлж байгаа, төрийн байгууллагууд хэрхэн хэрэгжилтэнд хяналт тавьж байгаа талаарх мэдээлэл олдоцгүй байна. УБ хотын “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын агуулгад нэн тэргүүнд ямар арга хэмжээг авч явуулах тухай болон хог хаягдал үүсэхээс сэргийлэх асуудал орхигдсон байна. Харин үйлдвэрлэгч болон импортлогч хариуцан эргүүлэн татах сав баглаа боодлын хаягдлын жагсаалтанд орсон хаягдлыг эргүүлэн

² [Plastic waste and recycling in the EU: facts and figures | News | European Parliament \(europa.eu\)](https://www.europa.eu/press-room/en/infographic-plastic-waste-and-recycling-in-the-eu-facts-and-figures)



татах ажлыг хэрэгжүүлэх үүднээс дахин боловсруулах хаягдлын төрөл, тэдгээрийг эргүүлэн татах ерөнхий заалт, мөн түүнчлэн Нийслэл хотод согтууруулах ундаа үйлдвэрлэгчид согтууруулах ундааны савны 30%-аас доошгүй хувийг эргүүлэн татах заалтууд тус тус оржээ. Энэ журмын гүйцэтгэлд хяналт тавих албан тушаалтан, тэдгээрийн үүргийн талаар болон журмыг хэрэгжүүлэхгүй тохиолдолд ноогдуулах хариуцлагын талаар мэдээлэл хэт ерөнхий байгаа нь энэ журмын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Нөгөө талаас Зөрчлийн тухай хуулийн 6.1 Хог хаягдлын тухай хуулийг зөрчих зүйлийн 26-д үйлдвэрлэгч импортлогч үүргээ биелүүлээгүйгээс үүдэн хохирол гарсан тохиолдолд нөхөн төлүүлж, торгууль ноогдуулах талаар тодорхой заалттай бөгөөд энэ талаарх хэрэгжилтийн мэдээлэл олон нийтэд олдоцгүй байна. Эрхзүйн орчин энэ чиглэлээр бүрэн бий бөгөөд зөвхөн хэрэгжилтийг хангуулахад холбогдох төрийн байгууллагын оролцоо шаардлагатай. Мөн энэ журмыг хотын иргэд, ААН-үүд мэдэхгүй байгаа бөгөөд таниулах, сурталчлах ажлыг хотын захиргаа нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Хөнгөн жингийн нийлэг уут ашиглалтыг хязгаарлах 2015/720 директив 2015 оноос ЕХ-ний улсуудад хэрэгжиж эхэлжээ. Энэ директивт хөнгөн жингийн гялгар уут гэж 50 микрон буюу 0.05 мм-ийн зузаантай уут, харин хэт хөнгөн жингийнх нь 15 микрон (0.015 мм) гэж ангилсан байна. Гялгар уутны хэрэглээ сүүлийн жилүүдэд хэт ихэссэнээс үүдэн байгаль орчин, ялангуяа гол мөрөн, нуур, далайд гялгар уутны хаягдлын улмаас усны амьтдад сөрөг нөлөө их учрах болсон нь энэхүү директивийг гаргахад хүргэжээ. Иймээс 2019 оноос нэг хүнд жилд ашиглах гялгар уутны тоо 90-с ихгүй, 2025 онд 40-с ихгүй байлгах бөгөөд хэт хөнгөн жингийн гялгар уутыг хэрэглээнээс хасах зорилтыг энэ директивт тусгажээ. Мөн байгальд бүрэн задрагч (охо-biodegradable өөрөөр охо-degradable) хэмээн сурталчилж хэрэглээнд нэвтрүүлж байгаа гялгар уутны чанарыг дахин нягталж, судлах шаардлагыг оруулжээ.
- Монгол улсад 0.035 мм-с нимгэн гялгар уутыг (нийлэг хальсан уут) хэрэглээнээс 2019 оноос хасах тухай Засгийн газрын 2018 оны №189 дугаар тогтоолд заасан бөгөөд одоогийн байдлаар хэрэгжилтийн тайлан мэдээлэл олдоцгүй байна. Хэрэглэгчийн ажиглалтаар энэ тогтоолтой холбоотой хүнсний дэлгүүрүүдэд үнэгүй савлагаанд ашигладаг байсан гялгар уутнуудын хог хаягдлыг багасгах зорилгоор дэлгүүрүүд худалдан авагчдадаа үнэлэн зардаг болсон. Харин нөгөө талдаа нимгэн гялгар уутны олдоц зах зээл дээр хэвээрээ байгаа нь хэрэглээнд тавих төрийн хяналт сул, тогтоолын хэрэгжилт байхгүй харагдаж байна. Үүнээс дүгнэхэд нимгэн гялгар уутны хэрэглээг зохицуулах энэхүү тогтоол хог хаягдлыг бууруулаагүй, харин ч дэлгүүрийн ашгийг нэмэгдүүлж, ард иргэдэд үнийн дарамт болсон байна. Хэрэв тогтоолын хэрэгжилтэнд тавих төрийн хяналт сайжирбал, тухайлбал, БОАЖЯ, ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн засаг дарга нар тогтоолын биелэлтийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Мэргэжлийн хяналтын байгууллагын тусламжтайгаар тогтмол хяналт тавих, Гаалийн ерөнхий газар хилээр оруулж буй бараанд хориглосон нийлэг хальсан уут байгаа эсэхэд хяналт тавьж, дэлгүүр, худалдааны төв, импортлогчдод сайн мэдээлэл өгч ажилласан

тохиолдолд тогтоолын зорилго биелэх магадлал бий. Мөн түүнчлэн манай хүнсний худалдааны том дэлгүүрүүдэд байгальд бүрэн задрагч нийлэг уутыг зарж байгаа нь сайшаалтай санаачилга бөгөөд төрийн зүгээс үүний чанарыг хянаж, үнэхээр байгальд бүрэн задардаг эсэхийг нь тогтоож, хувийн хэвшлийн санаачилгыг зөв чиглүүлэх ёстой.

- Зарим хуванцар бүтээгдэхүүний байгаль орчинд учруулж буй нөлөөллийг бууруулах тухай 2019/904 директивт Байгаль орчин, гол нуур, далайн эрэг орчмын нийт хог хаягдлын 80-85%-ийг хуванцар хаягдал эзэлдэг бөгөөд үүний 50%-ийг хүнс, ундааны нэг удаагийн хуванцар сав, 27%-ийг загас агнууртай холбоотой хуванцар хэрэгсэл, бусдыг нь тамхины нийлэг эдээр хийсэн шүүлтүүр бүхий иш, ус, ундаа, савны бөглөө, нийлэг нойтон алчуур, ариун цэврийн хэрэгсэл гэх мэт эзэлдэг. Эдгээр хуванцар хаягдлын улмаас байгаль орчин, усан орчин бохирдож, усны ургамал амьтдад сөрөг нөлөө учруулах явдал улам нэмэгдэж буйтай холбоотой тодорхой зорилтууд, авах арга хэмжээний удирдамжуудыг боловсруулан гишүүн орнууддаа гаргажээ. Энэхүү директивээр хаягдал их үүсгэж буй нэг удаагийн хуванцар хүнсний сав баглаа боодлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй бүтээгдэхүүнээр орлуулах боломжтой эсэхээр ангилан, бүтээгдэхүүн тус бүрээр хаягдлыг бууруулах зорилт, үйлдвэрлэгч борлуулагчийн өргөтгөсөн хариуцлага, бүтээгдэхүүний загварын шинэчлэл, шошгожуулалт, зах зээлд борлуулах хязгаар зэрэг олон талт арга хэмжээгээр зохицуулах арга хэмжээг тусган, зорилтыг хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжилтэд тавих хяналт, дүгнэх шалгуур үзүүлэлтээр гаргажээ.
- Энэхүү 2019/904 директивээс шинжлэн үзэхэд Хуванцар хаягдлыг дотор нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд хамгийн их сөрөг нөлөөтэй хуванцар хаягдлыг эх үүсвэр, төрлөөр ялган ангилж, хаягдал үүсэхээс сэргийлэх, дахин ашиглахад бэлтгэх, хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах зэрэг хог хаягдлын менежментийн тэргүүлэх ач холбогдол бүхий шатлалаар бодлого, арга хэмжээ авч буй энэ арга барилыг манай эрхзүйн баримт бичгүүдийг боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэхдээ зарчим болгон баримталбал хэрэгжилтийг хангуулахад дөхөм болох магадлалтай байна.
- ЕХПБЕЗ болон ЕК-ийн эдгээр эрхзүйн баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд хууль эрхзүйн баримт бичиг бүрт суурь түвшнээ тодорхойлж, үүнээс цаашид хэрхэн сайжруулах талаар хэмжигдэхүйц тодорхой зорилтууд, эдгээрийг биелүүлэх цаг хугацаа, биелэлтийг хянах шалгуур үзүүлэлтүүд, хяналтын механизмыг эрхзүйн баримт бичиг бүрээр тусгасан байгаа нь манай хууль эрхзүйн хүрээнээс ялгарах онцлог байгааг дурьдах нь зүйтэй.



БҮЛЭГ III.

Хуванцар хаягдлын зохистой удирдлагад эрхзүйн зохицуулалтын талаас тулгарч буй саад бэрхшээлийн тойм ба шийдэл

Хуванцар хаягдлын зохистой менежмент хийхэд тулгарч буй бэрхшээлийг энэхүү судалгаанд оруулсан өнөөгийн хууль эрхзүй, бодлогын баримт бичгийн болон Европын холбооны холбогдох эрхзүйн дүн шинжилгээнээс гадна Хуванцар хаягдлыг дахин боловсруулагчдын дунд хийсэн судалгааны зарим үр дүнг³ ашиглан гаргасан болно.

Хуванцар хаягдлыг дахин боловсруулагчдын дунд хийсэн технологийн суурь судалгааны явцад шийдэл хайсан дараах асуудлуудыг тавьж байлаа.

Үүнд:

- Хуванцар хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар хог хаягдлыг багасгах хууль эрхзүй байгаа хэдий ч энэ салбарт ажиллаж буй хувийн хэвшлийнхэнд бодитой дэмжлэг дутагдалтай байдаг;
- Төр засгаас гарч буй хуванцар хаягдалтай холбоотой хууль, дүрэм, журмыг боловсруулахдаа үйлдвэрлэгчдээс шийдлийн талаар санал хүсэлт авдаггүй, мэдээлэл хангалттай хүрдэггүй;
- Нэгэнт гарсан хууль дүрмийн талаарх мэдээлэл олон нийт, үйлдвэрлэгчдэд дутмаг, сургалт сурталчилгаа хүртээмжгүй байдаг;
- Дотоодын дахин боловсруулах үйлдвэрийн хийж буй бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн, тухайлбал, нийлэг уутнуудыг хил гаалиар хяналтгүй, гаалийн татваргүй, хямд үнээр оруулж байгаа нь дотоодын үйлдвэрлэгчдэд сөргөөр нөлөөлж, бүтээгдэхүүний борлуулалт буурч байгаа;
- Хэдийгээр хог хаягдлыг бууруулж, газарт булснаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс сэргийлж буй боловч нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөгддөггүй, харин ч үйл ажиллагааны явцад сөрөг нөлөө их гаргадаг бусад үйлдвэрлэлийн салбаруудтай ижил татвар төлдөг;
- Хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах чиглэлээр өөрсдөө ажлын байр бий болгож ажиллаж буй боловч ямар нэгэн эдийн засгийн урамшуулал, татварын хөнгөлөлт, цахилгааны хөнгөлөлт авдаггүй зэрэг асуудлыг хөндөж байлаа.

Эдгээр асуудлуудыг эрхзүйн зохицуулалтаар шийдэх боломжтой бөгөөд хуванцар хаягдлыг дахин боловсруулагчдыг бодлогоор дэмжиж эрхзүйн таатай орчныг бүрдүүлснээр хог хаягдлын салбарт төрийн оролцоо багасч, хувийн хэвшлийнхэн өөрсдөө ашигтай замаар хог хаягдлын зохицуулалтыг зах зээлийн зарчмаар, тогтвортой шийдэх боломжтой болох юм.

³ Монгол улс дахь хуванцар дахин боловсруулах бичил болон жижиг дунд үйлдвэрүүдийн технологийн суурь судалгааны тайлан, Баялаг Эко ХХК, 2021 он



Хуванцар хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, ашиглахад учирч буй саад бэрхшээлүүдийг арилгах үүднээс эдгээрийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн орууллаа. Эрэмбэлэх зорилго нь эрхзүйн сайжруулах чиглэлээр цаашид хийх ажлыг тодорхой болгох, хамгийн том саад бэрхшээлийг нэн тэргүүнд арилгахад чиглэсэн.

Одоогийн эрхзүйн орчинд байгаа хуванцар хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болох заалт

- а) Хог хаягдлын тухай хуулийн 8.1.8-д заасны дагуу гаргасан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын 2.1.1 заалтад тусгасан энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг зохих шатны засаг даргатай гэрээ байгуулсан, бүртгэлтэй иргэн аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ гэсэн заалтыг хуванцар хаягдлыг ангилах, цуглуулахад гол үүрэгтэй сайн дурын түүгчид хэрэгжүүлэхэд төвөгтэй, хэрэгжилтийг хянахад төвөгтэй тул албан бус түүгчид гэсэн бүлэг системийн гадна талд үлдэх магадлалтай ба хог хаягдлын мэдээллийн санг бодитой бүрдүүлэхэд саад болно. Ахуйн хэрэглээнээс гарч буй хуванцар хаягдал нь голцуу ундаа усны сав, хүнсний өргөн хэрэглээний барааны сав баглаа боодлын хуванцар бөгөөд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй учир, аэнгийн хуванцар хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх ажлыг заавал бүртгүүлж, гэрээ хийж гүйцэтгэх заалтыг өөрчилж, хялбаршуулах шаардлагатай. Нэгэнт албан бус хог түүгчдийн эрхэлж буй ажлыг хянах боломжгүйгээс хойш тэднийг хялбар байдлаар албажуулж нийгэмд хэрэгтэй энэ ажлыг хийх боломжийг олгох хэрэгтэй.

Одоогийн эрхзүйн орчны хэрэгжилтийг хангуулах

- а) Хог хаягдлын тухай хуулийн 10.2-р зүйлд заасан иргэн, ААН-үүдийн хүлээсэн үүрэг болон 9.1.3-д заасан энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын дагуу “энгийн хог хаягдлаа ангилан ялгах” үүргээ иргэн, ААН хангалтгүй бичлүүлж байгаа ба энэ үүргийн биелэлтэд төрөөс тавих хяналт ялангуяа айл өрхийн түвшинд байхгүй байна. Хуванцар хаягдлын статистик судалгааны⁴ үр дүнгээс үзэхэд Улаанбаатар хотод хаягдаж буй дахин боловсруулах боломжтой нийт хуванцар хаягдлын 17.1%-ийг жилд боловсруулж байгаа бөгөөд үлдсэн 82.9% нь эсвэл хаягдаж, эсвэл хогийн нэгдсэн цэгт газарт булагдаж байгаа нь байгаль орчин, эдийн засгийн хувьд маш хохиролтой асуудал юм. Мөн хуванцар хаягдлыг дахин боловсруулахад учирч буй томоохон нэг зардал нь хуванцар хаягдлыг боловсруулахын өмнө бохирдлыг цэвэрлэх ажилд зарцуулагддаг бөгөөд эх үүсвэр дээр нь буюу айл өрхийн түвшинд ангилан ялгасан тохиолдолдэнэ зардлыг

⁴ Монгол улсад дахь хуванцар хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төслийн Хуванцар хаягдлын суурь судалгааны тайлан, WRI. 2021 он



хэмнэх боломжтой, мөн дахин боловсруулах хуванцар хаягдлын хэмжээ хэмжээгээр нэмэгдэх боломжтой.

- b) Хог хаягдлын тухай хуулийн 6 дугаар бүлэг “Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалт”-д хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн бол эдийн засгийн урамшуулал олгох талаар болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А429/257 тушаалын хавсралтаар батлагдсан жагсаалтад багтсан зарим хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч хариуцах заалтуудын хэрэгжилтийг хангуулах нь нэн түрүүнд авч хэрэгжүүлэх ая холбогдолтой арга хэмжээ юм. Эдийн засгийн урамшуулал олгох журам 2017 онд боловсруулагдсан бөгөөд хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Одоогийн байдлаар 20 ААН урамшуулалд хамрагдаж, хөнгөлөлтэй зээлд хамрагдахаар болсон. ЕХ-ны хог хаягдлын директивт тусгасан нэн тэргүүн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэгдүгээрт хог хаягдал үүсэхээс сэргийлэх, хоёрдугаарт үйлдвэрлэгч импортлогчийн хариуцлагын асуудлыг тусгасан байдаг. Үйлдвэрлэгч, импортлогч эргүүлэн авах, хариуцах бүтээгдэхүүний сав боодлын доод хэмжээг тодорхойлох, зардлыг имдорт, худалдааны гэрээнд тодорхой тусгах, зардлын тодорхой хувийг дахин боловсруулагчдад, эсвэл хоёрдогч түүхий эдийн цэгүүдэд очих эсвэл тэдний зардлыг хэмнэх байдлаар хуваарилах зохицуулалтыг төрөөс хийх нь хог хаягдлыг бууруулах ажлыг зөв чиглэлд явуулахад том дэмжлэг болно.
- c) Нийслэлийн ИТХ-аас гаргасан журмын дараах заалтуудыг нэн тэргүүнд хэрэгжүүлэхэд анхаарч ажиллавал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх хог хаягдлын хэмжээ болон үүнтэй холбогдох зардал хэмнэгдэх, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө их хэмжээгээр багасах магадлалтай байна. Үүнд:
- Гурав дугаар бүлэг ААН, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо иргэдийн чиг үүрэг. 3.1.5 “иргэн, ААН байгууллага нь хогоо эх үүсвэр дээр нь ангилан ялгах” 3.1.6 “ ААН байгууллага сууц өмчлөгчдийн холбоо нь гадна талбайдаа энэ журмын 6.2-т заасан төрлөөр хог хаягдал хадгалах сав бункертэй байх ба доорх шаардлагыг хангасан байх”
 - 3.1.14 “Нийслэлд үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйлдвэрлэсэн, импортолсон РЕТ төрлийн хуванцар сав, шилэн лонх, сав, авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагчийн дугуй, хөнгөн цагаан болон метал лааз, сав бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хариуцах”
- d) Хог хаягдлын тухай хуулийн 41.6-д айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно гэсэн заалт “Монгол улсад дахь хуванцар хаягдлын дахин



боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл"-ийн зорилтот байршил буюу Улаанбаатар хот, Булган аймгийн хэмжээнд хэрэгжээгүй байна. Хэдийгээр энэхүү хуулийг дагалдах журмыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2020 онд батлагдсан боловч тарифыг шинэчлэн тогтоогоогүй байна. Булган аймгийн хог хаягдлын журам гараагүй бөгөөд хог хаягдлын хураамжийг 1 өрхөөр тооцон авч байгаа нь тухайн аймгийн төвийн сумын тохижилт үйлчилгээний анги тогтвортой үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны зардлаа нөхөхөд асуудал үүсгэж байна. Иймээс хог хаягдлын үйлчилгээний чанарыг сайжруулах, санхүүжилтийг бүрдүүлэхэд энэхүү заалтыг хэрэгжүүлэх ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна.

Эрхзүйн орчныг сайжруулах шаардлага

- a) Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журамд дараах асуудлыг шинэчлэн тусгаж хэрэгжилтийг хангах нь хаягдлыг дахин боловсруулагчдад эдийн засгийн бодитой дэмжлэг болно. Үүнд:
 - Хуванцар хаягдлын дахин боловсруулагчдыг нэмүү өртөгийн албан татвараас чөлөөлөх
 - Хуванцар хаягдлын дахин боловсруулагчдад цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлэх
 - Хөнгөлөлтэй болон ногоон зээлд хамрагдахад давуу эрх олгох
- b) Дотоодод үйлдвэрлэж буй ижил төстэй хуванцар бүтээгдэхүүн, нийлэг уутыг хяналтгүй, гаалийн татваргүй, хямд үнээр импортолж байгаа нь дотоодын үйлдвэрүүдийг үйлдвэрлэлээ хумих, зогсоох нөхцөл болж байгаа тул ижил төстэй нийлэг, хуванцар бүтээгдэхүүнд гаалийн татвар ноогдуулдаг болох замаар хог хаягдлыг дахин боловсруулах, ногоон ажлын байр бий болгох, хог хаягдлыг бууруулах бодлогыг дэмжих шаардлагатай.
- c) Хог хаягдлын тухайхууль, дагалдах журмуудыг Европын холбооны хог хаягдлын директивт тусгасан хог хаягдлын менежментэд баримтлах тэргүүлэх ач холбогдлын шатлалын зарчмыг (Бүлэг 4. эхний хэсэг) баримтлан сайжруулах шаардлага урган гарч байна. Энэхүү шатлалаар хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх бодлого, үйл ажиллагаа хамгийн тэргүүний авч хэрэгжүүлэх ажил болж байна. Тэрнээс нэгэнт үүссэн хог хаягдлын асуудал нь хоёр дахь ач холбогдолтой. Манай холбогдох эрхзүйн орчинд энэ асуудал "хог хаягдал аль болох үүсгэхгүй байх" гэсэн томъёоллоор орсон, үүнтэй холбогдон хийх ажил тодорхойгүй байна. Мэдээж нийгэм, эдийн засгийн олон салбарыг хамруулсан салбар хоорондын бодлого бөгөөд хэрэгжүүлэх механизмыг бий болгоход бүх салбарын идэвхтэй оролцоо, зохицуулалтууд шаардлагатай. Хог хаягдал үүсэхээс сэргийлэх нэн тэргүүний шаардлагад хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх судалгаа, арга хэмжээний тодорхой хөтөлбөр боловсруулж эрхзүйн баримт



бичигт тусгах ёстой. Үүний дотор, бүтээгдэхүүнүүдийн дизайныг хог хаягдал бага үүсгэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд хортой бодис агуулаагүй байдлаар боловсруулах, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх, баталгаажуулах зэрэг орно.

- d) ЕХ-ний эрхзүйд байгаа нэг шинэлэг санаа нь хог хаягдлын эрхзүйн баримт бичиг нь хэрэгжүүлэхэд хялбар илүү прагматик байна. Тухайлбал, хог хаягдлыг бууруулах ажилд тодорхой зорилтуудыг суурь төлөв байдлаас хэрхэн яаж сайжруулах талаар хэмжигдэж болохуйц хэлбэрээр дэвшүүлж, цаг хугацааны хязгаар тавьж өгсөн энэ зарчмыг манай эрхзүйн орчинд бодитой авч ашиглах шаардлагатай гэж үзэж байна. Мэдээж холбогдох өгөгдөл мэдээллийн тогтолцоог сайжруулсны үндсэн дээр зорилтуудыг гаргах шаардлага гарна. Үүний хирээр бодитой төлөвлөлт, шалгуур үзүүлэлт гаргах, холбогдох зардлыг илүү нарийвчлан гаргах шаардлагууд урган гарна. Хамгийн чухал нь хууль эрхзүйн орчин нь тунхаглал бус бодитой үр дүнд чиглэх болно.

Дээрх эрхзүйн орчныг сайжруулах чиглэлээр нэн тэргүүнд хийх шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэснээр хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглахад чиглэсэн зөв, тогтвортой менежмент бий болох боломжтой.



БҮЛЭГ IV.

Дүгнэлт ба Зөвлөмж

Хог хаягдлын зохицуулалтын өнөөгийн байдлыг эрхзүйн баримт бичгүүдийн бүрдэл, заалтуудын ач холбогдол, хэрэгжүүлэх боломж ба хэрэгжилт, байгууллагуудын үүрэг оролцоо, Европын холбооны холбогдох эрхзүйн орчны онцлог болон хуванцар хаягдлын зохистой удирдлагад тулгарч буй саад бэрхшээл ба шийдэл гэсэн чиглэлээр тунгаан шүүж үзэхэд дараах дүгнэлт гарч байна.

- Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017 онд батлагдсан. Хууль, түүнийг даган гарсан 16 журам заавар, аргачлал боловсруулагдан хэрэгжиж байна. Хог хаягдлын эрхзүйн орчин үндсэндээ бүрдсэн байна. Эдгээр хууль эрхзүйн орчны ихэнх заалтууд өнөөгийн шаардлагыг хангаж, зах зээлийн зарчимд нийцсэн гэж үзэж байна.
- Харин хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах эрхзүйн таатай орчныг бий болгоход дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:
 - Дахиврыг голлон сайн дураар цуглуулагч иргэдийг / албан бус түүгчид/ эрхзүйн зохицуулалтанд тооцоогүй ба иргэд сайн дураар энэ үйл дахивар цуглуулах, худалдах үйл ажиллагаанд өндөр шаардлагууд тавьж албан бус гэсэн ангилалд хамаарахад хүргэсэн;
 - Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахад иргэд ААН-үүдийг дэмжиж, урамшуулах журмыг нийслэлийн болон аймгийн ИТХуудаас гаргаагүй, тухайн чиглэлээр ажилладаг иргэд, хуулийн этгээдүүд дэмжлэг авах хүлээлт ихтэй байна;
 - Сум, дүүргийн нутагт дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хуульд заасны дагуу өрхийн гишүүн бүрээр тооцох ажил сум, дүүргийн ИТХ-р хэлэлцэгдээгүй;
 - Дахин боловсруулах боломжтой түүхий эд болон дахивар нөөцөөр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний таних тэмдгийн стандартыг байхгүй;
 - Хуванцар хаягдлыг ангилан ялгах, цуглуулах дахин боловсруулах чиглэлээр ажиллаж буй иргэд, ААН-үүдийг бодитой дэмжих эдийн засаг, гааль татварын зохицуулалтад дутмаг байгаа зэрэг асуудлууд байна.
- Нэгэнт бий болсон эрхзүйн баримт бичигт тусгагдсан шаардлагуудыг Монгол улсын иргэд, ААН, төрийн байгууллагууд амьдралд бодитой хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг мэргэжлийн хяналтын байцаагч, бүх шатны засаг дарга, цагдаа, хог хаягдлын олог нийтийн байцаагч, болон бусад хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан, төрийн бус



байгууллага хангуулах явдал чухал байгаагаас гадна иргэн иргэдийн бүлэг мэдлэг мэдээлэлтэй байж олон нийтийн хяналтыг давхар тавьж байх нь чухал байна. төрийн хууль хяналтын байгууллагын шууд оролцоо хангалтгүй байна.

- Хог хаягдлын хуулийн 10.2.1 болон орон нутгийн хог хаягдлын журмын шаардлагын дагуу айл өрх, ААН-үүд энгийн хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгах заалтын хэрэгжилтийг нэн түрүүнд хангуулах;
- Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч нь хариуцах, бараа бүтээгдэхүүний сав баглаа боодлыг эргүүлэн татах шаардлагын биелэлт хэрэгжилтийг хангуулсан тохиолдолд хог хаягдлын нийт 40 орчим хувийг эзэлж буй сав баглаа боодол, шил, хуванцар сав, мөн түүнчлэн авто машины дугуй, аккумулятор зэрэг зарим аюултай хаягдлын асуудал зөв зохицуулалтанд орох боломжтой.
- Хууль болон дагалдан гарсан бусад журмыг хэрэгжүүлээгүй иргэд, хуулийг этгээдэд ноогдуулах хариуцлагыг олон нийтэд таниулах, Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу ноогдуулах ажлыг бодитой хэрэгжүүлэх;
- Мөн шинээр гарч буй хууль, журмыг иргэд ААН-үүдэд таниулах, сурталчлах ажлыг нийслэлийн хог хаягдлын журамд заасны дагуу орон нутгийн захиргаанаас улиралд 2-оос доошгүй удаа зохион байгуулах шаардлагатай. Иргэд, аж ахуйн нэгжийн хууль журмын мэдлэг хангалтгүй байгаа нь хэрэгжилт хангагдахгүй байхад хүргэж байна. Мөн төрийн байгууллагуудаас шинээр хууль, журмыг боловсруулахдаа санал авах талаар мэдээллийг ард иргэд, ААН-д хүртээмжтэй хүргэх, саналыг харгалзан үзсэнээр хэрэгжилт нэмэгдэх боломжтой.

Зөвлөмж:

- Эрхзүйн хувьд хог хаягдлын зохистой менежментийг дэмжих үүднээс Европын холбооны холбогдох эрхзүйн орчинд баримталдаг тэргүүлэх ач холбогдлоор шаталдаг зарчмыг нэвтрүүлэхийг зөвлөж байна.
- Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах үйл ажиллагааг хариуцах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал, зөрчлийн тухай хуулийн үүнтэй холбогдох заалтын хэрэгжилтэд нэн тэргүүнд хяналт тавих нь хуванцар хог хаягдлын зонхилох хувийг эзэлж буй сав баглаа боодлын хаягдлын асуудлыг шийдэхэд чухал үүрэгтэй.
- Дараагийн тэргүүлэх асуудал нь хог хаягдлыг үүсэхээс сэргийлэх ажлыг дэлхий нийтээр баримталж буй тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл



санаачилга, ногоон хөгжлийн стратеги зэрэг бодлогын баримт бичгийн хүрээнд төрийн байгууллагууд, иргэд, бизнес, үйлдвэрлэлийн төлөөллүүдийг оролцуулан боловсруулж, үе шаттайгаар тууштай хэрэгжүүлэх шаардлагатай.

- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах үүднээс хуванцар хаягдлын дахин боловсруулах технологи, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд тавигдах стандарт шаардлагууд болон дахивраар хийсэн бүтээгдэхүүний шошго, таних тэмдгийг бусад орнуудын туршлага дээр үндэслэн боловсруулж, стандарт хэмжилзүйн үндэсний төвөөр батлуулах, цаашид үйлдвэрлэгчдээр дагаж мөрдүүлдэг болох шаардлага хэрэгцээ гарч байна.
- Дахивар бүтээгдэхүүнд тавигдах байгаль орчин, эрүүл мэндийн стандарт шаардлага, шошго тэмдэг бий болсноор төрийн болон төрийн оролцоотой орон нутгийн байгууллагууд төрийн хөрөнгөөр бүтээгдэхүүн худалдан авахдаа дахивраар хийсэн бүтээгдэхүүнийг таниж худалдан авахад дөхөм болох юм.
- Нийслэлийн Засаг даргын Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/492 захирамжаар батлагдсан журмын дагуу хороо тус бүрт нэгээс доошгүй олон нийтийн байцаагч томилон ажиллуулах заалтыг бодитой хэрэгжүүлэх нь хог хаягдлын чиглэлээр гарсан хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангуулах, хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулах асуудлыг шийдэхэд чухал ач холбогдолтой.
- Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журамд дараах асуудлыг нэмж тусгаж батлуулан цаашдын хэрэгжилтийг хангах нь хаягдлыг дахин боловсруулагчдад эдийн засгийн бодитой дэмжлэг болно. Үүнд:
 - Хуванцар хаягдлын дахин боловсруулагчдыг нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөх;
 - Хуванцар хаягдлын дахин боловсруулагчдад цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлэх;
 - Хөнгөлөлтэй болон ногоон зээлд хамруулах;
 - Дахивраар Монголд үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнтэй ижил төстэй бүтээгдэхүүний импортод ноогдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх замаар дотоодын дахин боловсруулагчдын үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах.
- Одоогийн хог хаягдлын тухай хууль, түүний дагалдах журам, заавруудыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах болон төрийн захиргааны бүх шатны байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх нь хог хаягдлын зохистой удирдлага бий болох хамгийн гол утгар нөхцөл болж байна. Иймээс холбогдох төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын дарга, ИТХ-ын гишүүд, албан тушаалтнуудын хууль



эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, давтан сургалтуудыг тасралтгүй явуулах хэрэгтэй. Төсөл хэрэгжиж буй Булган аймаг, Хишиг-Өндөр сумын хог хаягдлын эрхзүйг жишиг болгохуйц хэмжээнд боловсруулсны дараа бусад аймаг, сумдад түгээх нь холбогдох эрхзүйн орчин Улсын хэмжээнд сайжирч, цаашдын хэрэгжилтэнд сайн нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

